

まんがでわかる



Монгол хэл
モンゴル語


製材業の安全衛生

КОМИКООР МЭДЭХ

МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



Энэхүү дуу дүрст сургалтын материал нь мод боловсруулах үйлдвэрлэлийн ажлын талбайд ажилладаг та бүхэнд зориулсан аюулгүй байдал болон эрүүл ахуйн үндсэн мэдлэг олгоход зориулан боловсруулсан материал болно.



Өнөөдөр мод боловсруулах үйлдвэрлэлийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар суралцацгаая!




Мод бол бидний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгддэг, бидний сайн мэдэх материал юм.

Тийм шүү!



Мод боловсруулах үйлдвэрлэл гэдэг нь гуалинг гэр болон гэрийн тавилга зэргийн материал болгон боловсруулах ажил тийм ээ.


Сүүлийн үед байгалийн материалын үнэлэмж эргэн сайжирч байгаа.



Тийм ажлын талбарт ч гэсэн үйлдвэрлэлийн осол үүсдэг.

Аанхаа!


Тэгэхээр үйлдвэрлэлийн ослын гол шалтгааныг авч үзье.



Үйлдвэрлэлийн осол гарсан байдал

1	Хавчуулагдах, орооцолдох	30%
2	Зүсэх, зорох	20%
3	Өнхөрч унах, өндрөөс унах	12%
4	Ойчих	9%
5	Юм үсэрч ирэх, дээрээс юм унах	8%

Нэмэлт: Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх төв нийгэмлэг "Үйлдвэрлэлийн ослын шинжилгээний мэдээлэл" Үйлдвэрлэлийн осол гарсан байдал (2019 он) (Ослын тохиолдлын эзлэх хувийг 2019 онд гарсан бүх тохиолдолтой (506 осол) харьцуулан гаргасан)



"Хавчуулагдах, ороогдох", "Зүсэх, зорох", "Өнхөрч унах, өндрөөс унах" нь олон байдаг байх нь ээ...

Тийм байна.

Жишээлбэл,
"Хавчуулагдах, ороогдох"
тохиолдолд

Автомат конвейерийн ойролцоо
үзлэг хийж байх үед төхөөрөмж
ажиллуулах мэдрэгчид хүрснээр
төхөөрөмж ажиллан, цээжээрээ
хавчуулагдах зэрэг

Туузан дамнуургын эргэлдэгч голд
ажлын хувцас орооцолдох зэргийн
осол ч бас гарч байдаг.

Удаан хөдөлж байх үед ч
туузан дамнуурга нь
аюултай гэж сонсож
байсан шүү.

Туузан дамнуурга нь
харж байхад удаан хөдөлж байгаа ч
хүчтэй ажиллаж байдаг тул
гар зэрэг нь амархан
орооцолдчихдог юм.

Хэрхэн сэргийлдэг
юм болоо?

Тухайн хүний
анхаарал болгоомж бол
мэдээжийн хэрэг бөгөөд,
тогтоосон дүрэм болон ажлын
дарааллыг баримтлах нь
чухал шүү.

Олон
дүрэмтэй байх
төвөгтэй юм аа...

Гол нь болгоомжтой
байхад болох
юм биш үү?

Юу?

3, 3ааа!

Төвөгтэй байсан ч
өөрийгөө болон бусдыг
хохироохгүй байх
нь чухал!

Дараагаар нь "Зүсэх, зорох".
Дугуй хөрөөгөөр модыг
огтлохдоо гараа авах
тохиолдол байдаг.

Дугуй хөрөөг зогсоолгүй,
хөрөө арааман дахь модны
өөдсийг гараараа зайлуулах гэж
оролдох үед гараа авсан гэх
тохиолдол ч гардаг.

Гэмтэл авч ажил хийх
боломжгүй болбол
ар гэрийнхэн нь ч санаа зовж,
өрхийн орлого ч бас
хүнд болно...

Тийм учраас
аюулгүй ашиглах аргыг
сурч эзэмших нь
чухал байдаг.

Дугуй хөрөөний шүдэнд
хүрэх үед бүрэн унтраасан
байгаа эсэхийг
шалгаарай.

"Өнхөрч унах,
өндрөөс унах" нь
ямар үед бий болж байна?

Жишээлбэл,
машины засвар
үйлчилгээний үед,

тэнцвэрээ алдаж,
А шатнаас унах
тохиолдол ч бий.

Аанхаа....


Тэгэхээр дараа нь,





Бодит ажлын
талбайг

харцгаая!

1

CASE 1







Хичээл 1
"Төхөөрөмжид ойртох үед унтраалгыг унтраа."

CASE 2

Өнөөдөр нэлээн халуун байгаа учраас халуунд цохиулуузай. Ээлжлэн амрангаа ажлаа хийгээрэй.

Дотор муухайрвал нэрэлхэлгүй хэлээрэй.



Халуун байна....

Бээлийгээ тайлчихвал болохгүй байхдаа.

Өнөөдрийн ажилд заавал бээлий өмсөнө!

Хмм ... за яахав, хуруугаа хавчуулчихгүй л байвал болно биз дээ.

Ингэсгээд ээлжийн цаг боллоо!



Юу!!

Лай! Хажуунаас үглэнэ!

Аа!

Балараа! Төхөөрөмжийн мухарт...!

Эндээс хүрэхгүй шүү дээ!





Зүгээр үү!?

Яахаараа тэнд...!?



Нэвтрэх хориотой

Яасан!?

Нэвтрэх хориотой бүсэд юу хийж байгаа юм!



Бээлийгээ унагачихаад... Авах гэтэл туузан дамнуурга гэнэт хөдлөөд хуруугаа хавчуулчихлаа...!



Хавдсан юм биш үү!

Эмнэлэг яаралтай яв!



Хэд хоногийн дараа



Хугалсан хуруу нь яаж байна?

Бага зэрэг өвдөж л байна ...

Анзаараагүйд уучлаарай...



Үзлэгийн явцад тэжээл өгч болохгүй

Хамгаалах хэрэгсэл өмсөхгүй байх нь сайнгүй хэдий ч,

Төхөөрөмжийг зогсоосон юм бол мэдэгдлийг заавал гаргах нь ажлын дүрэм биз дээ.



Нэвтрэх хориотой

Тэгээд, нэвтрэх хориотой бүс бол аюултай учраас тийшээ орж бас болохгүй,

Туузан дамнуургын эргэдэг хэсгүүдэд яасан ч хүрч болохгүй ээ.




Мэдэгдлийг мартах тохиолдол байдаг тул, дур мэдэн тэжээл өгөх нь аюултай шүү.

Асаахаас өмнө асууж байхыг хүсье.

За...

Хичээл 2 "Тэжээлээс салгасан бол бусдадаа мэдэгдье."

CASE 3



* Дугуй хөрөөний ирийг солих хугацаа нь модон материалын чанар болон ажилласан хэмжээнээс хамааран ажлын талбар болгонд ялгаатай байдаг.



Модны үртэс овоорчихож.

Одоо төхөөрөмжийг зогсоолоо.



Чи!

Дугуй хөрөөг зогсоогоод модны үртсийг цэвэрлээд өгөхгүй биз?

За!



Тэжээлийг салгаад...



Дугуй хөрөө зогсохоор модны үртсийг цэвэрлэхэд л болно биз дээ...?



Узлэг хийж байна самбар өлгөөд...

Узлэг хийж байна



Шинэ хөрөөний ир хаана байлаа?

Тэр тавиуранд.



Ингэсгээд болох байхаа.



Модны үртсийг цэвэрлэх үү дээ...



Аюултай!

Гараа ойртуулж болохгүй!!

юуу...?

бийй



Аа!


Ааааа!!



Зүгээр үү!?

Цус тогтоогоод шууд эмнэлэг яв!

Шууд холбоо барьчхаад ирье!!



5 оёдол тавиулсан уу?

Тийм...



Дугуй хөрөө бага зэрэг эргэлдэж байсан ч аюултай учраас,

яаралгүйгээр зогссон эсэхийг шалгаад ажлаа хийхгүй бол хүнд гэмтэл авахад хүргэнэ шүү.

STOP!


ЗОГС!



Тэгээд, заасан ажлын дүрэм дарааллыг баримтлах хэрэгтэй!

Дугуй хөрөөн дэх модны үртэс нь аюултай учир гараараа биш агаарын буу болон сойзоор цэвэрлээрэй.



Бээлий өмсөөгүй байсан бол илүү том шарх авах ч байж магадгүй шүү.



Цаашдаа болгоомжтой байнаа...

Хичээл 3
"Төхөөрөмжид хүрэхдээ бүрэн зогссон эсэхийг шалгаж байж хүрч байх *"

* Ялангуяа хөдлөх эд анги нь аюултай!



Мод боловсруулах үйлдвэрлэлд анхааруштай гол санаа



1 | Унтраалгыг унтраах



Модны тайрдас болон модны үртсийг цэвэрлэхэдээ унтраалгыг унтраацгаая.

2 | Эргэн тойронд байгаа бусдадаа мэдээлэх



Төхөөрөмжийг зогсоож арчилгаа хийх үедээ самбар өлгөж тавьцгаая.

3 | Зогссон эсэхийг шалгах




Үзлэг хийхийн өмнө төхөөрөмжийг бүрэн зогссон эсэхийг шалгацгаая.

4 | Аюултай бүс рүү нэвтрэхгүй байх



Аюултай бүсэд нэвтрэхгүй байхаар ажиллацгаая.



Мод боловсруулах үйлдвэрлэл

Эдгээр зүйлүүдэд ч анхааралтай байцгаая!

Аюулгүй, эрүүл байх зөвлөмжүүд!



1 | Хамгаалах хэрэгсэл, тоноглол




Санаа
Тохиромжтой хамгаалах хэрэгслийг өмсөхийг анхаарцгаая. Дэлгэрэнгүйг "Комикоор мэдэх Аюулгүй байдал эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн үндэс"-с.

2 | Халуунд цохиулахаас болгоомжил




Санаа
Ажлын талбар дотор болон гадаа халуунд цохиулахаас болгоомжил! Дэлгэрэнгүйг "Комикоор мэдэх Аюулгүй байдал эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн үндэс"-с.

3 | Өндөр газраас унахаас болгоомжил



Санаа
Шат болон А шат ашиглан өндөр газар ажиллахдаа болгоомжил. Дэлгэрэнгүйг "Комикоор мэдэх Аюулгүй байдал эрүүл ахуй болон үйлдвэрлэлийн ослоос сэргийлэхийн үндэс"-с.

4 | Аюулгүйн төхөөрөмж байгаа эсэхийг шалгацгаая




Санаа
Аюулгүйн төхөөрөмж нь үнэн зөв ажиллаж байгаа эсэхийг шалгацгаая!


Ажлын талбар дээр ажиллаж байхад нуугдах эрсдэлийг мэдэцгээе!

Аюулыг урьдчилан таних сургуулилт (АУТС)

Q Асуулт: Хаана аюултай вэ гэдгийг бодоорой!



A Хариулт: Энэ бол аюулын үндэс!



1

Гараа халаасанд хийхгүй.



2

Хориотой бүсэд нэвтэрч болохгүй.



3

4S (Зохион байгуулалт, Эмх цэгц, Цэвэрлэгээ, Цэвэр байдал)-г ягштал хэвшүүлэх.



Өөр аюул ослын цэг байгаа эсэхийг бодоорой.

КОМИКООР МЭДЭХ

МОД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

2022 оны 3-р сарын хэвлэл


Хэвлүүлсэн: Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яам

Төлөвлөн хэрэгжүүлсэн: Mizuho Research & Technologies, Ltd.

Хамтран ажилласан: Модон материал, модон эдлэлийн үйлдвэрлэлийн аюулгүй байдал, эрүүл ахуйн боловсрол сургалтын материал боловсруулах ажлын хэсэг

Хэвлэсэн: Sideranch Inc.

Модон материал үйлдвэрлэлийн тойм



* Өөдөсний түүхий эдэд сийрэгжүүлэн унагасан мод болон ойн үлдэгдлээс гадна модон материалын эцсийн материал болон орон сууц, барилга зэрэгт ашиглагдсан хаягдал материалыг ч ашигладаг.



Энэ материалтай холбоотой холбоо барих
Эрүүл мэнд, Хөдөлмөр, Халамжийн яамны
Хөдөлмөрийн стандартын товчооны
Аюулгүй ажиллагааны хэлтэс,
Аюулгүй байдал, эрүүл ахуйн газар